*Төсөл*

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

## ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/23 дугаар зүйлийн 23.4.1 дэх заалт:

“23.4.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д заасан орлого болон мөн зүйлийн 20.1.2-т заасан суурь хувиар тооцсон орлого;”

2/23 дугаар зүйлийн 23.6.10 дахь заалт:

“23.6.10.энэ хуулийн 23.4.1-д зааснаас бусад аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр | Дугаар ... | Төрийн ордон, Улаанбаатар хот

## ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.15 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх импортыг орлох, экспортыг дэмжих салбар, үйл ажиллагаа, төслийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

*Монгол Улсын Их Хурлын 2025 оны*
*......... дугаар тогтоолын хавсралт*

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ХӨНГӨЛӨХ ИМПОРТЫГ ОРЛОХ, ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ САЛБАР, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

| БҮС | САЛБАР |
|---|---|
| Хангайн бүс | |
| | |
| Баруун бүс | |
| | |
| Хойд бүс | |
| | |
| Төвийн бүс | |
| | |
| Зүүн бүс | |
| | |
| Говийн бүс | |
| | |

*<u>Төсөл</u>*

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .....дугаар сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

## МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “15.1.6, 15.1.9” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.